

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСЛИЙН
МАГАДЛАЛЫН НЭГТГЭСЭН ДҮГНЭЛТ

2020 оны 4 дугаар
сарын 30 өдөр

Дугаар 700/
2020

Улаанбаатар-15171
Утас: 323022, 328097
Факс:

Барилга, байгууламжийн байршил, нэр, зориулалт:	Дорнод аймгийн Баянтүмэн суманд баригдах “20 ортой эрүүл мэндийн төвийн барилга”-ын ажлын зураг төсөл, төсөв Шифр: До-02/2020
Хүчин чадал:	Барилгын хэмжээ: Тэнхлэгээрээ 36.0 м x 16.0 м хэмжээтэй, Давхрын тоо: ±0.00 түвшнээс дээш 2 давхар, 20 ортой Барилгын ашигтай талбай: S = 929.0 м ²
Захиалагч:	Дорнод аймгийн ГХБХБГазар
Санхүүжилтийн эх үүсвэр:	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар /Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XVII.1.52-р хууль/
Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгчийн нэр:	“ДОЗТ” БГБХН
Регистрийн дугаар:	РД: 2305046
Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа:	2023.11.22
Ажлын төрөл:	1.2.1, 1.2.6 заалтын дагуу
Зураг төсөл боловсруулах үндэслэл:	
Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх, олгосон захирамж, дугаар огноо:	Дорнод аймгийн Баянтүмэн сумын Засаг даргын 2011 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/83 тоот захирамж, Төрийн байгууллагын газар эзэмших эрхийн 000440042 дугаартай гэрчилгээ
Архитектур төлөвлөлтийн даалгавар, баталсан албан тушаалтан, дугаар, огноо:	Дорнод аймгийн Ерөнхий архитекторын 2019 оны 5 дугаар сарын 13-ны өдөр баталсан 12/2019 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавар
Зургийн даалгавар баталсан албан тушаалтан, дугаар, огноо:	Дорнод аймгийн Засаг даргын 2020 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр баталсан “Дорнод аймгийн Баянтүмэн сумын 20 ортой эрүүл мэндийн төвийн барилга”-ын зураг төсөл боловсруулах даалгавар, Дорнод аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга, “ДОЗТ” БГБХ Нөхөрлөлийн захирал нарын хороонд 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан “Дорнод аймгийн Баянтүмэн сумын 20 ортой эрүүл мэндийн төвийн барилга”-ын ажлын зураг төсөл боловсруулах гэрээ
Зөвшөөрөлцсөн байгууллагууд:	
Дорнод аймгийн Ерөнхий архитектор	Ц.Цоггэрэл
Зүүн бүсийн төв ОБГ-ын дарга, хурандаа	Г.Нармандах
Дорнод аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга	Д.Мөнхтуяа

Дорнод аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга		Д.Дамдинбазар	
"Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХК-ийн Дорнод аймгийн газрын дарга		Б.Билэгт	
"Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХК-ийн Дорнод аймгийн газрын ерөнхий инженер		Н.Шинэхүү	
Техникийн нөхцөл олгогдсон байдал:			
Техникийн нөхцөлүүд:	Олгосон байгууллага:	Дугаар, огноо:	Хүчинтэй байх хугацаа:
Дулаан хангамж:	Энэ тохиолдолд шаардлагагүй		
Ус хангамж, ариутгах татуурга:	Энэ тохиолдолд шаардлагагүй		
Цахилгаан хангамж:	"ДБЭХС" ТӨХК	№ 2019/74 2019.05.17	2 жил
Холбоо дохиолол:	"Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХК-ийн Дорнод аймгийн газар	№ ТН-А15/2019 2019.05.14	1 жил
Барилга, байгууламжийн зураг төслийн бүрэлдэхүүн:			
Зураг төслийн иж бүрдэл:	Зураг төсөл гүйцэтгэсэн байгууллагын нэр:		Магадлал хийсэн экспертийн нэр:
Ерөнхий төлөвлөгөө, өндөржилт, барилга архитектур:	"ДОЗТ" БГБХН		Д.Өлзийсайхан
Барилга бүтээц:	"ДОЗТ" БГБХН		Г.Сарантуяа
Халаалт, агаар сэлгэлт, гадна дулаан:	"Жаргал проект" ХХК		Ц.Жалцав
Гадна, дотор ус хангамж, ариутгах татуурга:	"Жаргал проект" ХХК		Т.Чимид-Очир
Дотор гэрэлтүүлэг, хүчит төхөөрөмж, цахилгаан хангамж:	"Итгэлийн хад" ХХК		Б.Түмэннаст
Гадна, дотор холбоо, дохиолол:	"Итгэлийн хад" ХХК		Ж.Зоригт
Төсөв:	"ДОЗТ" БГБХН		Л.Цэрэнбалтав
Инженер геологи:	"Бигс" ХХК /Архив № ЗТ12-1833/17/		Дүгнэлт баталгаажсан
Нэгтгэсэн дүгнэлт: /Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоол/			
Барилга байгууламжийн техник-эдийн засгийн үзүүлэлт, зураг төслийн үндсэн төлөвлөлт, техникийн шийдлийн талаар тусгасан товч тодорхойлолт;	<p>Барилга, байгууламж баригдах газрын байгаль, цаг уурын ерөнхий өгөгдөл: Гадна агаарын температур -32.7 °С Цасны ачаалал 50 кг/м² Салхины ачаалал 42 кг/м² Галд тэсвэрлэлтийн зэрэг II</p> <p>Барилгын буурь хөрсний үзүүлэлт: Судалгааны талбай инженер геологийн дунд зэргийн төвөгтэй нөхцөлтэй. Суурь суух буурь хөрсний талбайд 2 төрлийн хөрс илэрсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - ИГЭ-1 Жижиг ширхэгтэй элс, - ИГЭ-2 Шавранцар <p>Ул хөрсний шинж чанар:</p> <ul style="list-style-type: none"> - Улирлын хөлдөлтийн норматив гүн жижиг ширхэгтэй элсэн хөрс 2.9, шавранцар 		

	<p>хөрсөнд 2.4 м,</p> <ul style="list-style-type: none"> - Жижиг ширхэгтэй элсэн хөрс нь овойлтгүй, шавранцар хөрс нь дунд зэрэг овойлттой хөрсөнд нормчлогдоно, - Хөрсний ус 3.5-3.7 метрийн гүнд илэрч тогтсон, - Газар шорооны ажлын жижиг ширхэгтэй элсэн хөрс I, шавранцар хөрс II зэрэг, - Хөрсний хувийн цахилгаан эсэргүүцэл жижиг ширхэгтэй элсэн хөрс усгүй үед 100-500 Ом/м, устай үед 40-200 Ом/м, шавранцар хөрс усгүй үед 10-70 Ом/м, устай үед 10-25 Ом/м, - Газар хөдлөлийн 5 балл <p>Хөрсний механик шинж чанарын үзүүлэлт:</p>															
	<table border="1"> <thead> <tr> <th data-bbox="718 683 1077 750">Хөрсний нэр</th> <th data-bbox="1077 683 1284 750">ИГЭ-1</th> <th data-bbox="1284 683 1477 750">ИГЭ-2</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="718 750 1077 862">Барьцалдах хүч: $C^H = \text{кПа}$</td> <td data-bbox="1077 750 1284 862">2</td> <td data-bbox="1284 750 1477 862">32</td> </tr> <tr> <td data-bbox="718 862 1077 974">Дотоод үрэлтийн өнцөг: $\Phi^H = \text{C}^\circ$</td> <td data-bbox="1077 862 1284 974">30</td> <td data-bbox="1284 862 1477 974">19</td> </tr> <tr> <td data-bbox="718 974 1077 1086">Хэв гажилтын модуль: $E = \text{МПа}$</td> <td data-bbox="1077 974 1284 1086">28</td> <td data-bbox="1284 974 1477 1086">20</td> </tr> <tr> <td data-bbox="718 1086 1077 1176">Тооцооны эсэргүүцэл $R_0 = \text{кПа}$</td> <td data-bbox="1077 1086 1284 1176">200</td> <td data-bbox="1284 1086 1477 1176">250</td> </tr> </tbody> </table>	Хөрсний нэр	ИГЭ-1	ИГЭ-2	Барьцалдах хүч: $C^H = \text{кПа}$	2	32	Дотоод үрэлтийн өнцөг: $\Phi^H = \text{C}^\circ$	30	19	Хэв гажилтын модуль: $E = \text{МПа}$	28	20	Тооцооны эсэргүүцэл $R_0 = \text{кПа}$	200	250
Хөрсний нэр	ИГЭ-1	ИГЭ-2														
Барьцалдах хүч: $C^H = \text{кПа}$	2	32														
Дотоод үрэлтийн өнцөг: $\Phi^H = \text{C}^\circ$	30	19														
Хэв гажилтын модуль: $E = \text{МПа}$	28	20														
Тооцооны эсэргүүцэл $R_0 = \text{кПа}$	200	250														
	<p>Барилга, байгууламжийн төлөвлөлт: Барилга нь тэнхлэгээрээ 36.0 м x 16.0 м хэмжээтэй, ± 0.00 түвшнээс дээш 2 давхар байхаар төлөвлөгдсөн байна. Барилгын гадна тохижилтод явган зам талбай, авто зам, зогсоол, ногоон байгууламж төлөвлөсөн байна. Гадна довжооны хэсэгт "Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн гарын авлага" /БД 31-101-04/, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орон зай, орчны зураг төсөл төлөвлөлт" /БД/31-112-11/-ийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж налуу зам төлөвлөсөн байна. 1-р давхарт: Үзлэгийн өрөө, тарианы өрөө, коридор, цахилгааны техникийн өрөө, салхивчийн өрөө, ариун цэврийн өрөө, салхивчийн нэгдсэн системийн өрөө, шатны хонгил, боолтын өрөө, дархлаажуулалтын өрөө, вакцин хадгалах өрөө, бохир хаягдлын өрөө, агуулах, хоол бэлтгэх, угаалгын өрөө, гал тогоо, ажилчдын амрах өрөө, ажилчдын хувцас солих өрөө, цэвэр, бохир хэрэгсэл хадгалах өрөө, угаалгын өрөө, туслах өрөө, хүлээн авах, гонх, үүдний хэсэг, эмийн сан, эм хадгалах өрөө, сургалтын өрөө, дулааны техникийн өрөөг,</p>															

2-р давхарт: Архив, дүн бүртгэл, нягтлан, нярвын өрөө, салхивчийн нэгдсэн системийн өрөө, шатны хонгил, хэвтэн эмчлүүлэх өрөөнүүд, сувилагчийн өрөө, төрх өрөө, төрсний дараах өрөө, төрхийн өмнөх өрөө, ариун цэврийн өрөөнүүд, лабораторийн өрөө, эрүүл мэндийн төвийн даргын өрөө, чийрэгжүүлэлтийн өрөө, коридор, эр, эм хувцас солих өрөө зэргийг тус тус төлөвлөсөн байна.

Үндсэн бүтээц нь:

Суурь: Цутгамал төмөр бетон шугаман суурьтай,

Даацын үндсэн бүтээц: Барилга нь тоосгон өрөгт бүтээцтэй,

Гадна хана: 510 мм-ийн зузаан тоосго, 100 мм-ийн зузаан галд тэсвэртэй полистирол хавтан дулаалга,

Хучилт: Угсармал төмөр бетон нүхтэй хавтан хучилттай,

Дээвэр: Дулаалгатай хавтгай дээвэртэй байхаар тус тус төлөвлөсөн байна.

Халаалт, агаар сэлгэлт:

Дулаан хангамжийн эх үүсвэр нь одоо байгаа халаалтын зуухнаас хангагдахаар төлөвлөсөн байна.

Төлөвлөж буй барилгын халаалтыг доогуур түгээлттэй, хоёр хоолойт мухардмал эргэлттэй систем, агаар сэлгэлтийг ердийн болон механик ажиллагаатай системтэй байхаар тус тус төлөвлөсөн байна.

Хашлага хийцийн дулаан дамжуулалтын коэффициент:

$K_{гх} = 0.2 \text{ Вт/м}^2 \cdot \text{°C}$, $K_{ху} = 0.22 \text{ Вт/м}^2 \cdot \text{°C}$, $K_{ц} = 2.0 \text{ Вт/м}^2 \cdot \text{°C}$,
 $K_{гад хаал} = 2.27 \text{ Вт/м}^2 \cdot \text{°C}$

Дулааны нийт ачаалал: $Q_{бүгд} = 97100.0 \text{ Вт}$

Дулаан зөөгчийн температур: $90^\circ/70^\circ \text{ C}$

Цэвэр бохир ус:

Барилга доторх ус хангамжийг ахуйн болон галын ус хангамжийн системтэй байхаар төлөвлөж, барилгаас гарах бохир усыг өөрийн урсгалаар нь нэгтгэн бохир усны худагт холбож зайлуулахаар төлөвлөсөн байна.

Цэвэр, бохир усны тооцоо: $q_{бүгд} = 3.0 \text{ м}^3/\text{хон}$,
 $q_{хүй} = 1.35 \text{ м}^3/\text{хон}$, $q_{хал} = 1.65 \text{ м}^3/\text{хон}$, $q_{бох} = 3.0 \text{ м}^3/\text{хон}$,
 $q_{гал} = 2.5 \text{ м}^3/\text{хон}$

Хучит төхөөрөмж, дотор гэрэлтүүлэг:

Хэрэглэгчид цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааны I ба II зэрэглэлд хамаарагдах тул тэжээлийг бие биеэсээ үл хамаарах хос кабель шугамаар хангахаар төлөвлөсөн байна.

Газардуулга, аянга хамгаалалтыг төлөвлөсөн байна. Цахилгаан байгууламжийн дүрмийн дагуу газардуулгын эсэргүүцэл 4 Ом-оос хэтрэхгүй байх шаардлагатай. Сүлжээний хүчдэл 380/220В байна.

Үндсэн үзүүлэлт:

Оролт-1: $P_{г1} = 32.96 \text{ кВт}$, 51.1А

	<p>Оролт-2: $P_{T2} = 32.7$ кВт, 50.7А</p> <p>Дотор холбоо дохиолол: Барилгын холбоо дохиоллын системд хотын телефон, интернетийн сүлжээ, кабелийн телевиз, хяналтын камер, галын дохиоллын систем, зарлан мэдээлэх систем зэргийг тус тус төлөвлөсөн байна.</p> <p>Гадна дулаан хангамж: Одоо байгаа эмнэлгийн халаалтын зуухны барилга дотор шинээр НРЖ маркийн зуух суурилуулж 2Ф50 мм-ийн голчтой ган хоолойтой 93.5 метр урт дулааны шугам шинээр татаж холболт хийхээр төлөвлөсөн байна.</p> <p>Ус хангамж, ариутгах татуурга: Одоо байгаа эмнэлгийн халаалтын зуухны барилгаас Ф32 мм-ийн голчтой цайрдсан ган хоолойгоор огтолгоо авч 93.5 м урт цэвэр усны шугам татаж холболт хийхээр төлөвлөсөн байна. Төлөвлөж буй барилгын ахуйн бохир ус нь өөрийн урсгалаар зайлуулагдах бөгөөд шинээр хийх 20.0 м³ эзэлхүүнтэй бохир усны цооногт холболт хийхээр төлөвлөсөн байна.</p> <p>Ариутгах татуургын сүлжээг Ф160 мм-ийн голчтой 67.8 метр урт хуванцар хоолойгоор угсрахаар төлөвлөсөн байна.</p> <p>Гадна цахилгаан хангамж: Техникийн нөхцөлийн дагуу одоо байгаа КТП-58 дэд станцын баруун хойш гарсан 0.4 кВ-ын самбарыг нэг гаргалгаагаар өргөтгөн УКШ39-9-19 маркийн төмөр бетон тулгууртай СИП 3х70+1х54.6 мм² хөндлөн огтлолтой 0.4 кВ-ын агаарын шугамыг АKN-2 тулгуур хүртэл татна. АKN-2 тулгуураас АВБШв 3х70+1х35 мм² хөндлөн огтлолтой 0.4 кВ-ын кабель шугам татаж эмнэлгийн барилгын ерөнхий оролтын самбар, АВБШв 4х10 мм² хөндлөн огтлолтой кабель шугам татаж АВР-тай самбар, гадна гэрэлтүүлгийн самбарыг тус тус тэжээхээр төлөвлөсөн байна.</p> <p>Трассын урт:</p> <ul style="list-style-type: none">- СИП 3х70+1х54.6 мм² хөндлөн огтлолтой агаарын кабель 600.0 м,- АВБШв 3х70+1х35 мм² хөндлөн огтлолтой кабель 170.0 м,- АВБШв 4х10 мм² хөндлөн огтлолтой кабель 403.0 м <p>Гадна холбоо: Техникийн нөхцөлийн дагуу одоо байгаа эмнэлгийн барилгын шилэн кабелийн төгсгөлийн төхөөрөмжөөс 12 корын шилэн кабель салаалан авч шинээр хийх худаг, сувагчлалаар дамжуулан татаж төлөвлөж буй барилгад оруулан шилэн кабелийн төгсгөлийн төхөөрөмж холбохоор төлөвлөсөн байна.</p> <p>Трассын урт:</p> <ul style="list-style-type: none">- 1+0 сувагчлал 112.0 м
--	---

	- 12 корын шилэн кабель 150.0 м			
Зураг төслийн сонгосон шийдэл, магадлал хийх явцад экспертээс өгсөн нэмэлт, өөрчлөлтийн саналыг зураг төсөлд тусгасан эсэх;	Чиглэл тус бүрийн орон тооны бус экспертийн саналыг зураг төсөлд тусгасан байдал: Экспертүүдийн өгсөн үүрэг даалгаврын дагуу зураг төсөлд засвар өөрчлөлтүүдийг хийсэн байна.			
Эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, барилга байгууламжийн нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргасан эсэх;	Хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргасан байдал: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "20 ортой эрүүл мэндийн төвийн барилга" баригдсанаар иргэдэд төрийн зүгээс үзүүлэх эмнэлгийн анхан шатны тусламж хурдан шуурхай тохилог орчинд үзүүлэх таатай нөхцөл боломж бүрдэх юм.			
Төсөвт өртгийн нэгдсэн товчоо				
№	Барилга угсралтын ажлын			
	Тодорхойлолт	Төсөвт өртөг /төг/	Хүчин чадал	Нэгж өртөг /төг/
1	<u>а/. Эмнэлгийн барилга угсралтын ажил:</u>			
ББ	Барилга: тэнхлэгээрээ 36.0 м х 16.0 м хэмжээтэй Давхрын тоо: Зоорьгүй, 2 давхар	972,499,424.0	1,021.4	952,086.7
ХАС	Талбайн хэмжээ: 1021.4 м2 Суурь: Цутгамал төмөр бетон шугаман суурьтай	155,791,173.0	1,021.4	152,521.1
ЦБУ	Үндсэн хийц: Тоосгон өрөгт бүтээцтэй Гадна хана: 510 мм-ийн зузаан	46,797,873.0	1,021.4	45,815.6
ДГ-ХТ	тоосго, 100 мм-ийн зузаан полистирол хавтан дулаалга Хучилт: Угсармал төмөр бетон	68,696,188.0	1,021.4	67,254.3
ХД	нүхтэй хавтан хучилттай Дээвэр: Дулаалгатай хавтгай дээвэртэй	33,332,420.0	1,021.4	32,632.8
	Хэсгийн дүн:	1,277,117,078.0	1,021.4	1,250,359.4
2	<u>б/. Гадна инженерийн шугам сүлжээний ажил:</u>			
ГДГ	Гадна дулаан /м/: Үл нэвтрэх угсармал сувагт ган хоолой 2Ф50 мм	42,330,996.0	93.5	452,738
	Дулааны узель /ком/: Халаалтын тогоо 200 кВт, бусад тоног төхөөрөмжийн угсралт	39,444,582.0	1.0	39,444,582
УХ	Гадна ус хангамж /м/: Дулааны сувагт ган хоолой Ф32 мм	4,016,263.0	93.5	42,955
АТ	Гадна ариутгах татуурга /м/: Бохир усны хуванцар хоолой Ф160 мм	9,261,217.0	67.8	136,596
БЦ	Бохир усны цооног /м3/: Цутгамал төмөр бетон цооног 20м3	18,066,809.0	20.0	903,340

ГЦ- ДШ	Гадна цахилгаан /м/: 0.4 кВ-ын кабель шугам АВБ6ШВ 3x70+1x35 мм2	9,494,632.0	107.4	88,404
ГЦ- ДШ	Гадна цахилгаан /м/: 0.4 кВ-ын агаарын шугам СИП 3x70+1x54.6 мм2	7,448,413.0	507.9	14,665
ГГ	Гадна гэрэлтүүлгийн тэжээл /м/: 0.4 кВ-ын кабель шугам АВБ6ШВ 4x10 мм2	10,912,502.0	373.0	29,256
	Гадна гэрэлтүүлэг /ш/: Нэг толгойтой гадна гэрэл 12 ширхэг, 2 толгойтой гадна гэрэл 7 ширхэг	20,565,656.0	19.0	1,082,403
ГХ	Гадна холбоо /м/: 1+0 сувагчлал	12,904,580.0	112.0	57,610
	Гадна холбоо /м/: Сувагчлалын 12 корын шилэн кабель		112.0	
Хэсгийн дүн:		174,445,650.0		
3	<u>в/. Гадна тохижилтын ажил:</u>			
ГТ	Явган зам, талбай /м2/: Өнгөт хавтан хучилттай	42,986,287.0	1,229.0	34,976.6
	Авто зам, зогсоол /м2/: Бетон хучилттай	39,924,054.0	691.5	57,735.4
	Авто зам, талбай /м2/: Хайрган хучилттай	1,030,369.0	122.0	8,445.6
	Ногоон байгууламж /м2/: Зүлэгжүүлэлт	7,797,158.0	515.0	15,140.1
	Гадна хашаа /м2/: 1.5 м өндөр төмөр сараалжин хайс	26,200,590.0	387.2	67,666.8
Хэсгийн дүн:		117,938,458.0		
4	<u>г/. Зураг төслийн үнэ:</u>			
ЗТҮ	Зураг төслийн үнэ	49,710,200.0		
Хэсгийн дүн:		49,710,200.0		
НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:			1,619,211,386	

Төсөв: Эксперт нь Дорнод аймгийн Баянтүмэн суманд баригдах "20 ортой эрүүл мэндийн төвийн барилга"-ын ажлын төсөвт өртгийг **1,619,211,386** (нэг тэрбум зургаан зуун арван есөн сая хоёр зуун арван нэгэн мянга гурван зуун наян зургаан) төгрөгөөр хянасан байна.

"Барилгын тухай" Монгол Улсын хуулийн /шинэчилсэн найруулга 2016 он/ 38.1.2-т "барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсгийг боловсруулсан зохиогч тухайн зураг төслийг баталгаажуулан, мэргэжлийн хариуцлага хүлээх", 38.1.3-т "зураг төсөл зохиох хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэн эсэхэд хяналт хийж баталгаажуулан, хариуцлага хүлээх", 39.4-т "Эксперт барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсэгт магадлалын дүгнэлт гаргаж, мэргэжлийн хариуцлага хүлээх", 39.5-д заасны дагуу "Экспертийн эрх бүхий хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотолж, техникийн шийдлийн талаарх дүгнэлт гаргаж, хариуцлага хүлээнэ".

Дорнод аймгийн Баянтүмэн суманд баригдах "20 ортой эрүүл мэндийн төвийн барилга"-ын ажлын зураг төсөл, төсөвт "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм", "Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм" /БНБД 81-94-12/, "Барилгын төсөв зохиох дүрэм" /БНБД 81-95-12/-ийг тус тус үндэслэн магадлал хийх ажлыг зохион байгуулж, нэгтгэсэн дүгнэлт бичсэн болно.

Нэгтгэсэн дүгнэлт нь экспертүүдийн **18** хуудас магадлалын дүгнэлтийн хамт хүчинтэй.

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛД
МАГАДЛАЛ ХИЙХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН:**

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ

Ц.АМАРСАНАА

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН
ЗУРАГ ТӨСӨЛ МАГАДЛАЛЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Э.ХАНГАЛ

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН
ЗУРАГ ТӨСӨЛ МАГАДЛАЛЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.САРАНТУЯА

